



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй, 153000 метр квадрат талбай бүхий, нийт 9,987,840,000.00 (есөн тэрбум есөн зуун наян долоон сая найман зуун дөчин мянга) төгрөгийн балансын үнэтэй “газар эзэмших эрх”-ээс хавсралтад заасны дагуу 102000 метр квадрат талбай бүхий, нийт 6,658,560,000.00 (зургаан тэрбум зургаан зуун тавин найман сая таван зуун жаран мянга) төгрөгийн балансын үнэтэй газар эзэмших эрхийг данснаас хасч Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдэлд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Минжинхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Газар эзэмших эрхийг шинэчлэн баталгаажуулж арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000365

6-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

"ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БИЕТ БУС ХӨРӨНГӨД БҮТГЭЛТЭЙ ДАНСНААС ХАСАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Байршил	Нэгж талбарын дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Данснаас хасах метр квадрат	Данснаас хасах үнэ (төгрөг)
1	Газар эзэмших эрх (Үнсэн сангийн зориулалттай, Э-2205001327 дугаартай)	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо	1681910170	м.кв	153000	9,987,840,000.00	102000	6,658,560,000.00
Нийт дүн								
						9,987,840,000.00	102000	6,658,560,000.00
						(есөн тэрбум есөн зуун наян долоон сая найман зуун дөчин мянга)		(зургаан тэрбум зургаан зуун тавин найман сая таван зуун жаран мянга)